

узуулэх тухай даалгаврыг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг баринтална.

2. Даалгавар хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжинд хэрэв харшлахгүй бол тэр Этгээдийн шуух хусэлтээ явуулж байгаа шуухийн даалгаварт дурдсан хэлбэр, журмын дагуу даалгаврыг биелүүлж болно.

Арван дөрөвдүгээр зүйл

1. Даалгаврыг биелүүлэхэд хүлээн авч байгаа шуухийн эрх хэмжээ хурэлцэхгүй бол уг даалгаврыг эрх бүхий өөр шуухэд шилжуулнэ.

2. Даалгавар хүлээн авч байгаа шуух уг даалгаврыг хаана, хэзээ биелүүлэхээ цаг тухайд нь даалгавар явуулсан шуухэд ыууд мэдэгдэж байна,

3. Даалгаварт дурдсан кргэн заагдсан хаягт оршин суудагтуй бол даалгавар хүлээн авч байгаа шуух хаягийг топоох арга хэмжээ өөрийн санаачлагаар авка.

4. Эрхийн туслалцаа узуулэх тухай даалгаврыг **биелүүлэх** бололцоогуй бол тэр тухай болон туунийг биелүүлэхэд саад болсон шалтгаакыг даалгавар хүлээн авч байгаа шуух даалгавар явуулж байгаа шуухэд мэдэгдэнэ.

Баримт бичиг гардуулах тухай
даалгавар

Арван тавдугаар зүйл

I*. Даалгавар хүлээн авч байгаа шуух энэхуу Гэрээний I3-р зүйлийн заалтыш дагуу бичиг баримтыг гардуулах тухай даалгаврыг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

2. Бичиг баримт нь хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хэл дээр хийгдээгүй буюу тэдний хэл дээр хийгдсэн